

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
3.1	Аудит хийсэн үр дүнгийн тайлан	9
3.2	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
3.3	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3.4	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН СУДАЛГААНЫ
ИНСТИТУТИЙН ЗАХИРАЛ
М.АЛТАНСҮХ ТАНАА

2019.02.25 № 06/234
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр төсвийн гүйцэтгэлд материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус сангийн төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн ХЭДС-гийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус институтийн захирал М.Алтансүх Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаархи тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаархи тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн ХЭДС-гийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 02 дугаар сарын 22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ”Төгс нягт гурав аудит” ххк-ний захирал Д.Цэнд хянан удирдаж, чанарын хяналтын менежер З.Тунгалаг, аудитор Д.Эрдэнэтуяа, аудиторын туслах С.Баярсайхан нар хэрэгжүүлэв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн ХЭДС-гийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн Төгс нягт гурав аудит ХХК-д 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 13 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаархи бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрхи стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрхи бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн ХЭДС-гийн талаархи ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Тус байгууллага Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор 2017 онд байгуулагдсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн үндсэн зорилго нь төрөөс хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, хөтөлбөрийн суурь судалгаа шинжилгээ, хэтийн болон ойрын тооцоолол хийж, зөвлөмж боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн байгууллага юм.

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр зэрэг томоохон бодлогын баримт бичигт холбогдох хууль журам, тэдгээр журмыг шинэчлэхэд шаардлагатай суурь тоон мэдээлэл, зөвлөмжөөр хангах зорилтын хүрээнд “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа”, “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”, “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”, судалгааг хийж үр дүнг тайлагнасан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн ХЭДС-гийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараахь хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын ХЭДС-гийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “AXPLORER 3.16” програм хангамж ашигладаг байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын ХЭДС-гийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Материаллаг байдлын түвшинг тооцох суурийг сонгохдоо төсвийн уламжлалт ба хяналтын эрсдэл бага гэж үзэн төлөвлөлтийн шатанд Санхүүгийн тайлан дахь санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын санхүүжилтийн дүнгээс 1 хувиар буюу 2431,2 мянган төгрөгөөр тооцсон нь өөрчлөгдөөгүй байна.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь төсөвт байгууллагад санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын үед голчлон төсвийн хөрөнгийн зарцуулалтыг авч үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж үнэлэлэхэд дээрх 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд зөвлөмж өгөх шаардлагагүй гэж үзэн зарим материаллаг бус алдааг залруулах зөвлөмжийг аудитын явцад өгсөн болно.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн ХЭДС чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдон 2018 онд 243,120.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 242.995.558 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 124.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нийлээд 2018 оны санхүүгийн тайлангийн жилд нийт 5 төсөл хэрэгжүүлсэний “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа”, “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”, “Гурван тулгуурт хөгжлийн бодлого” зэрэг 3 төслийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн байна.

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын дагуу төслийн хүрээнд олгогдсон цалин хөлс, бусад орлого, байгуулсан гэрээ хэлэлцээрийн ач холбогдол, үр дүнг аудитлахад зөрчил илрээгүй болно.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн ХЭДС-гийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, ажлын гүйцэтгэл, бусад холбогдох мэдээллийн талаар байгууллагын gilsr.gov.mn вэбсайт хуудсанд хугацаанд нь оруулж хяналт тавьж ажиллсан байна. 2018 оны 11 дүгээр сард Үндэсний аудитын газраас шилэн дансны хэрэгжилтийн талаар аудит хийсэн бөгөөд аудитаар зөрчил илрээгүй байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж өгөгдөөгүй болон 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн ХЭДС-гийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн ХЭДС-гийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	500,000,000.00	243,120,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	500,000,000.00	243,120,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	500,000,000.00	243,120,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	500,000,000.00	243,120,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	407,088,019.00	124,442.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	407,088,019.00	124,442.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	407,088,019.00	124,442.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	315,400,958.00	242,995,558.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	315,400,958.00	242,995,558.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	91,687,061.00	124,442.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	91,687,061.00	124,442.00

3.2 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>500,000,000.00</u>	<u>243,120,000.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>500,000,000.00</u>	<u>243,120,000.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	500,000,000.00	243,120,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	500,000,000.00	243,120,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>500,000,000.00</u>	<u>243,120,000.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>500,000,000.00</u>	<u>243,120,000.00</u>
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<u>500,000,000.00</u>	<u>243,120,000.00</u>
2132	Бусад урсгал шилжүүлэг	408,312,939.00	242,995,558.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	408,312,939.00	242,995,558.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	91,687,061.00	124,442.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	91,687,061.00	124,442.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.3 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	593,197,981.00	408,312,939.00	243,120,000.00	242,995,558.00	124,442.00	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	593,197,981.00	408,312,939.00	243,120,000.00	242,995,558.00	124,442.00	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	593,197,981.00	408,312,939.00	243,120,000.00	242,995,558.00	124,442.00	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	593,197,981.00	408,312,939.00	243,120,000.00	242,995,558.00	124,442.00	99.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	593,197,981.00	408,312,939.00	243,120,000.00	242,995,558.00	124,442.00	99.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	593,197,981.00	408,312,939.00	243,120,000.00	242,995,558.00	124,442.00	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	593,197,981.00	408,312,939.00	243,120,000.00	242,995,558.00	124,442.00	99.9
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	593,197,981.00	408,312,939.00	243,120,000.00	242,995,558.00	124,442.00	99.9

3.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Хөтөлбөрийн код	Зориулалт, арга хэмжээний код	ЭЗ Ангилал 2015	Үзүүлэлт	Тохируулга
00000	00000	2	НИЙТ ЗАРДАЛ	-
00000	00000	21	УРСГАЛ ЗАРДАЛ	-
00000	00000	213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-
00000	00000	2131	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-
00000	00000	261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	124,442.00
72102	82616	000000	НИЙТ ОРЛОГО	124,442.00
72102	82616	000000	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	124,442.00
72102	82616	000000	Улсын төсвөөс	124,442.00
72102	82616	2	НИЙТ ЗАРДАЛ	124,442.00
72102	82616	21	УРСГАЛ ЗАРДАЛ	124,442.00
72102	82616	213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	124,442.00
72102	82616	2131	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	124,442.00
72102	82616	2132	Бусад урсгал шилжүүлэг	-
72102	82616	213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-
72102	82616	261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	124,442.00
72102	82616	310002	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	124,442.00

ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines for writing.

ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines for writing a summary.

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.